

Төв Азийн аюулгүй байдал, геополитикийн асуудал

Доржпаламын Эрдэнэцогт

Доктор (Ph.D), ахлах шинжээч, erdenetsogt@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Төв Азийн улсуудыг түүх, хэл, соёл, шашин, далайд гарцгүй байдал, зөвлөлтийн дараах тусгаар тогтнол, аюулгүй байдлын сорилт зэрэг нийтлэг зүйл нэгтгэдэг. Мөн Төв Азийн геостратегийн онцгой байршил, байгалийн баялгийн нөөц нь их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлыг татаж буй.

Төв Ази дахь “C5+1” түншлэл, гадаадын хөрөнгө оруулалт, бүсийн улсуудын нийтлэг ашиг сонирхол нь аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн гол үндэс суурь болж байна. Тиймээс Төв Ази нь цаашид их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөний талбар болох эсвэл аюулгүй байдал, улс төр, эдийн засгийн бие даасан томоохон “тоглогч” болох уу гэдэг нь бүс нутгийн улсуудын нэгдмэл ашиг сонирхол, хамтын ажиллагаанаас шалтгаалах төлөвтэй байна.

Түлхүүр үг: Харилцаа, хамтын ажиллагаа, түншлэл, чиг хандлага

Оршил

ЗХУ 1991 онд задарч, Төв Азид исламын шашинтай, тусгаар тогтносон таван улс бий болсноор Евроазийн аюулгүй байдал, геополитикт Төв Ази хэмээх шинэ орон зай үүсэж, их гүрнүүдийн сонирхлыг татаж эхэлсэн. Ялангуяа Төв Азийн улсууд түүхт “Торгоны зам”-ын гол зангилаа буюу Өрнө-Дорно хооронд худалдаа, эрчим хүч, байгалийн баялгийг дамжуулах гол судас болж байгаа нь их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхол, өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Улмаар түүхэн соёл иргэншил, далайд гарцгүй байдал, зөвлөлтийн дараах тусгаар тогтнол, түрэг хэл, исламын шашин шүтлэг, аюулгүй байдлын нийтлэг сорилтыг нь нэгтгэснээр Төв Ази буюу “C5” гэсэн бие даасан бүс нутаг болж хөгжих чигтэй байна.

Нэг. Төв Ази дахь аюулгүй байдлын орчин, их гүрнүүдийн ашиг сонирхол ба “C5+1” түншлэл

Төв Азийн улсуудын аюулгүй байдлын орчинд олон улсын терроризм, хэт даврах болон салан тусгаарлах үзэл, газар нутаг, бэлчээр, хилийн маргаан, эрчим

хүч, усны хомсдол, үндэстэн хоорондын мөргөлдөөн, нийгэм-улс төрийн дотоод зөрчил хямрал, хил дамнасан хар тамхины наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг сорилт сөргөөр нөлөөлдөг¹.

Афганистанаас Төв Азийн улсуудад орж ирсэн исламын шашны урсгал нь Ислам, Аль-Каида зэрэг террорист бүлэглэлийн хоргодох түшиц газрыг бий болгож, цаашид салан тусгаарлах үзэл Ирак, Сирийн хувилбараар өрнөж болзошгүй байгаа нь бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлөх гол эрсдэл болж байна. Тухайлбал: Хятад, Афганистан, Пакистаны хил дамнан оршдог Тажикистаны Горно-Бадахшан өөртөө засах орон нь нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэх улс төрийн сөрөг хүчин, шашны радикал бүлгүүдийн “үүр уурхай” болон хувирчээ. Талибаны засаглал, Хаккани сүлжээ бүлэглэлийн дэмжлэгтэйгээр Аль-Каида нь исламын зэвсэгт бүлэглэлийн Сири, Ирак дахь ялагдлыг далимдуулан шинээр гишүүд элсүүлэх, санхүүжилт татах, дэлхийн хэмжээнд салбараа нэмэгдүүлэх замаар алсдаа “Ариун дайн”-аа үргэлжлүүлэн хийх зорилготой байгаа нь илт. Ийм нөхцөл байдал нь Төв Азийн улсуудын аюулгүй байдлыг хангах бүс нутгийн механизм, хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагыг нэмэгдүүлж байна.

Төв Азийн улсуудын аюулгүй байдлыг хангах архитектур механизмд ШХАБ, ЕАБХАБ, АХАИББХ², ХАБГБ, ТУХН, ЕАЭЗХ зэрэг олон талт харилцааны байгууллага болон найрамдал, хамтын ажиллагааны хоёр талын гэрээ, “C5+1” зэрэг бүс нутгийн болон гадаад улсуудын хамтарсан түншлэлүүд ордог. “C5+1” түншлэлийн хэлбэр нь бүс нутгийн аюулгүй байдал, тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистик зэрэг салбарт хамтран ажиллахад чиглэдэг.

Америкийн зүгээс Афганистаны “аюул” нэрийн дор бүс нутгийн хил хязгаар, аюулгүй байдлыг бэхжүүлэх, терроризмын эсрэг тэмцэх зорилгоор цэргийн салбарт хамтран ажиллаж байгаа нь учиртай. Үүний зэрэгцээ сургалт, бэлтгэл, техник хэрэгслээр хангах, Өрнөдийн түншлэгч орнууд болон НАТО-гийн гишүүн Туркээр дамжуулан Төв Азид нөлөөгөө нэмэгдүүлэх, ардчиллын үнэт зүйлсийг түгээх замаар Москва, Бээжингийн нөлөөг сааруулах бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Төв Азийн улсууд төрийн тэргүүн нарынхаа зөвлөлдөх уулзалтыг сүүлийн жилүүдэд тогтмолжуулж, Америк, Энэтхэг, Япон зэрэг Өрнөдийн улстай “C5+1” түншлэл хэлбэрээр, Түрэгийн улстай соёл иргэншлээр, исламын улстай шашин шүтлэгээрээ эвлэлдэн нэгдэж байгаа нь Орос, Хятадтай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. “C5+1” түншлэл нь Төв Ази дахь Орос, Хятадын нөлөөг хязгаарлах, Өрнөдийн хөрөнгө оруулалтыг дэмжих, ялангуяа Энэтхэг, Саудын Араб, Европын хооронд худалдааны коридор байгуулах зорилгыг агуулжээ³. Мөн Казахстан, Киргиз, Узбекистан нь түрэг үндэстнүүдийн хамтын ажиллагааны олон

¹ ICC, https://en.icc.org.cn/thinktank_theories/intl_observation/399.html, (Татсан: 2025.11.11)

² Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал

³ The Astana Times, <https://astanatimes.com/2025/08/decade-of-c51-experts-observe-advanced-regional-cooperation-in-central-asia/>, (Татсан: 2025.11.01)

улсын байгууллагад, Төв Азийн улсууд Исламын хамтын ажиллагааны байгууллагад тус тус элссэн нь Орос, Хятадын ашиг сонирхолд нийцэхгүй байгаа нь тодорхой юм. Орос, Хятадын зүгээс Ази, Африк, Европын улсаар ШХАБ-ын хүрээг өргөтгөх бодлого явуулж байна. Өөрөөр хэлбэл: ШХАБ-ыг Төв Азийн бүс нутгаасаа хальж, Евроази, Энэтхэг-Номхон далайн орон зайд аюулгүй байдлын томоохон механизм, цэрэг-улс төрийн шинжтэй дэлхийн дэг журмын нэгэн шинэ төв болж, хөгжүүлэх зорилготой.

Төв Азийн аюулгүй байдал, геополитикт Орос, Америк, Хятад, Энэтхэг, Турк, Иран, Пакистан, Европын Холбооны ашиг сонирхол бодитойгоор нөлөөлж байна. Төв Азийн улсуудын хувьд ОХУ аюулгүй байдал болон тогтвортой байдлыг хангах баталгаа болдог. Харин БНХАУ эдийн засгийн баталгааг хангаж байна. Энэ хоёр их гүрний ашиг сонирхол нэг талаасаа хамтрагч, нөгөө талаасаа стратегийн өрсөлдөгч шинжийг агуулж байна. Тухайлбал: Афганистан болон исламын террористуудын аюулаас Төв Азийг хамгаалж, тогтворжуулах зорилготой Оросын хамгийн том цэргийн бааз Тажикистанд 25 жил байрлаж байгаа бол Хятадын “Бүс ба Зам” санаачилга Төв Азийн улсуудад амжилттай хэрэгжиж байна.

Дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүд Төв Азийг чиглэсэн “C5+1” түншлэлийн хэлбэрээр хамтын ажиллагааг хөгжүүлж, ашиг сонирхлоо бэхжүүлэх ашиг сонирхолтой.

БНХАУ: Ши Жиньпин дарга 2023 онд Шиан хотод болсон “C5+Хятад” уулзалтаар худалдааны шинэ коридорын Их бүтээн байгуулалтын төлөвлөгөөг танилцуулсан нь Төв Ази дахь Хятадын геоздийн засгийн ашиг сонирхлыг илэрхийлж байна. Мөн тус уулзалтаар Хятад-Төв Азийн харилцааны шинэ эрин үеийг зарлаж, “Дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцох гэсэн гадаадын улсын аливаа оролдлогыг тууштай эсэргүүцэх”-ээ илэрхийлсэн нь Оросоос Төв Азийг “өмөөрөх” хандлага улмаар Орос, Хятадын ашиг сонирхлын далд зөрчил гэж үзэж болно. Бээжин Төв Азийн улсуудын байгалийн баялаг, эрчим хүчний нөөцийг ашиглах, хятадын бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл, Европ руу гарах транзит тээврийн гол маршрут болгох, “Бүс ба Зам” бодлогоо хэрэгжүүлэх зэрэг геоздийн засгийн шинжтэйгээс гадна хөрөнгө оруулалтаа хамгаалах цэргийн оролцоог давхар санаархаж байгаа нь тодорхой. Тухайлбал: Тажикистаны өмнөд нутгийн Афганистантай хиллэдэг уулархаг районд Хятадын цэргийн хоёр баазыг байгуулсан⁴. Энэ нь ШХАБ-аар дамжуулан бүс нутгийн улсуудтай харилцаагаа гүнзгийрүүлж, Шиньжаан Уйгурын өөртөө засах бүс нутагт тогтвортой байдлыг бий болгох бодлоготой мөн холбоотой.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин Казахстан, Тажикистанд 2024 онд төрийн айлчлал хийж, мөн оны сүүлчээр өндөр албан тушаалтнууд Хятадыг Киргиз, Узбекистантай холбох төмөр замын төслийн нээлтийн ёслолд оролцсон нь Төв Азид Хятадын улс төр-дипломат, худалдаа-эдийн засгийн нөлөө нэмэгдэж буйг харуулна.

⁴ Jamestown, <https://jamestown.org/program/china-increasing-its-military-presence-in-tajikistan/>, (Татсан: 2025.11.02)

АНУ: Ерөнхийлөгч Ж.Байден 2023 онд Нью-Йорк хотноо болсон “C5+АНУ” дээд хэмжээний уулзалтаар Төв Азид аюулгүй байдал, тогтвортой байдал, харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжихээ илэрхийлсэн нь Америкийн улс төрийн зорилгыг илтгэнэ. Үүнд: Төв Азийн улсуудад Орос, Хятадын нөлөөг бууруулах, ардчиллын үнэт зүйлсийг түгээх, эрчим хүчний нөөцөд хяналт тавих, Иранд улс төр, эдийн засгийн дарамт үзүүлэх цэг (hub) болгон ашиглахад оршиж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампын урилгаар 2025 оны 11 дүгээр сарын 6-нд Вашингтон хотноо “C5+АНУ” дээд хэмжээний уулзалт болсон нь Төв Ази дахь АНУ-ын геостратегийн бодлогын үргэлжлэл юм⁵.

ОХУ: “C5+ОХУ” түншлэлийн хэлбэр нь улс төр-дипломат, аюулгүй байдал, худалдаа-эдийн засаг, тээвэр, харилцаа холбоо, хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицол, эрчим хүч, халдвар хамгааллын байдал, цагаачлал ба хүмүүнлэг гэсэн есөн салбарт хэрэгжиж байна. Тухайлбал: Хүмүүнлэгийн салбар нь Оросын соёл иргэншил, орос иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилготой бөгөөд түншлэлийн хүрээнд орос хэлний олон улсын байгууллагыг бий болгож, 2023 оныг “Орос хэлний жил”, 2025 оныг “Фашизм нацизмыг эсэргүүцэх жил” болгосон. ОХУ-д ажиллаж, амьдарч байгаа цагаачид (хууль ёсны болон хууль бус)-ын дийлэнхийг Төв Азийн улсуудын харьяалалтай иргэд эзэлдэг нь эдийн засгийн хөгжлийн түвшин, ажилгүйдэл болон хуучин Зөвлөлтийн үед тогтсон нийгэм-эдийн засгийн интеграц одоо ч хүчтэй хэвээр байгаатай холбоотой юм. Эдгээр нь ОХУ-д газрын тос, байгалийн хийн хоолой, авто зам, төмөр зам зэрэг дэд бүтцийн хуучин тогтолцоо болон ТУХН, ХАБГБ, ЕАЭЗХ зэрэг механизмаа ашиглан Төв Азийг хяналтдаа байлгах ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу байдлыг бий болгодог.

Европын Холбоо: Төв Азийн бүс нутгийг Хятадтай хийх худалдааны транзит тээврийн гол маршрут болгох, эрчим хүч, байгалийн нөөцийг нь ашиглаж, Орос, Америкаас хараат байдлаа тэнцвэржүүлэх, хөрөнгө оруулах, хүний эрх, хууль ёс зэрэг Өрнөдийн үнэт зүйлсийг “нутагшуулах” геополитик баримталж байна. Европын Холбоо болон Төв Азийн улсуудын хооронд улс төр, аюулгүй байдлын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтыг Бельгийн нийслэл Брюссель хотноо 2024 оны зургаадугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж, терроризм, хүчирхийлэл, хэт даврах үзэл, хар тамхины наймаатай тэмцэх, хилийн менежмент, кибер аюулгүй байдлын асуудлыг хэлэлцсэн нь энэ бодлоготой холбоотой.

Европын Холбоо, Төв Азийн улсуудын удирдагчдын “C5+EX” анхны дээд хэмжээний уулзалтыг Самарканд хотод 2025 оны дөрөвдүгээр сард зохион байгуулсан. Тус уулзалтаар Европын улсуудад ногоон эрчим хүч нийлүүлэх, газрын ховор металл, цахим шилжилт зэрэг чухал салбарт хамтарсан төслийг хэрэгжүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн байна. Дээд түвшний уулзалтын төгсгөлд Түншлэлийн тухай хамтарсан тунхаг бичигт талууд гарын үсэг зурж, хоёр бүс нутгийн эдийн засаг, хүмүүнлэг, технологийн интеграцчилалд чиглэсэн томоохон багц санаачилгуудыг баталжээ.

⁵ The Diplomat, <https://thediplomat.com/2025/10/washington-to-host-central-asian-leaders-on-november-6/>, (Татсан: 2025.11.06)

БНЭУ: Энэтхэг нь Төв Азийн улсуудын хувьд стратегийн найдвартай түнш, эдийн засаг, техник, технологийн томоохон хөрөнгө оруулагчийн нэг. Бүс нутаг дахь Делигийн геополитикийн ашиг сонирхол нь нэгдүгээрт, Төв Азийн бүс нутгийг тогтвортой байлгах, хоёрдугаарт, Энэтхэг-Пакистаны зөрчилдөөнд бүс нутгийн улсуудыг төвийг сахисан байр суурийг баримтлуулах, гуравдугаарт, шашны хэт даврах үзэл орж ирэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэжээ. Улмаар “Энэтхэг Төв Азийг холбоно” стратегийн уриан дор Энэтхэг, Төв Азийн улсуудын Төрийн тэргүүн нарын анхны дээд хэмжээний “C5 + Энэтхэг” уулзалтыг 2022 онд зохион байгуулсан бөгөөд ирэх онд дахин болох төлөвтэй.

ИБНПУ: Пакистаны хувьд Төв Азийн улсуудтай ойрын харилцаатай байхыг чухалчилдаг. Энэтхэг, Пакистаны алинд нь ч Төв Азийн бүс нутаг нь Европ руу гарах эдийн засгийн гол гарц гэдгээрээ чухал ач холбогдолтой бөгөөд харин тэдэнд цэрэг-стратегийн ашиг сонирхол одоогоор байхгүй гэж болно.

ИБНИУ: Ираны гадаад бодлогод Төв Азийн бүс нутаг онцгой байр суурь эзэлдэг нь нэн тэргүүнд түүх, соёл, исламын шашинтай холбоотойгоос гадна байгалийн баялгийн асар их нөөц, хүн амын нягтрал, газар нутгийн өргөн уудам орон зай нь тус улсын хувьд эдийн засгийн хөгжлийн маш том боломж гэж үзэн, бүс нутгийн хамтын ажиллагаанд аль болохоор идэвхтэй оролцох тодорхой бодлого баримталж байна.

Япон улс, БНСУ: Төв Азид худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Япон, Өмнөд Солонгос аль аль нь “C5+1” түншлэлийг хэрэгжүүлсэн. Өмнөд Солонгостой Төв Азийн улсуудад Зөвлөлтийн үеэс ажиллаж амьдарч буй 200 мянга гаруй солонгос үндэстэн талуудын хамтын ажиллагааны нэг чухал гүүр нь болж байна.

БНТУ: Турк Төв Азийн улсуудын хүн амын түрэг угсааг ашиглаж, шашин, соёлын салбарт хамгийн хүчтэй нөлөөлж байгаагаас гадна эдийн засгийн харьцангуй таатай бодлого явуулж, байр сууриа улам бэхжүүлж байна. Турк Төв Азийн улсуудад өөрийн нутаг дэвсгэрийг Европ руу гарах гарц болгон чөлөөтэй ашиглуулж байгаа нь Түрэгийн улсуудын хооронд хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх замаар өөрийн нөлөөний бүс болгох алсын зорилготой холбоотой гэж ойлгож болно.

Хоёр. Төв Азийн геополитик, аюулгүй байдлын чиг хандлага

Төв Ази дахь Туркийн оролцоо нь өнгөн дээрээ зөвхөн эдийн засаг, соёлын салбарт нэгэнт олсон байр сууриа бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа мэт боловч энэ бүс нутгийн цэрэг-улс төрийн бодлогыг тодорхойлогч гол тоглогч болох гэсэн санаархал нь цаашдаа Орос, Хятадын ашиг сонирхолтой зөрчилдөхөд хүргэж болзошгүй байна. Тухайлбал: Туркийн ашиг сонирхол давамгайлсан Төв Азийн дөрвөн улсыг нэгтгэсэн Түрэгийн улсуудын байгууллага нь зөвхөн Төв Азийн төдийгүй Евроазийн орон зайд Түрэгийн ертөнцийн геополитик, геоэдийн засаг, интеграцын гол механизм болон хөгжих хандлагатай байгаа нь энэ бүс нутгийг чиглэсэн Орос, Хятадын ашиг

сонирхолтой шууд зөрчилдөх юм. Бишкек хотноо өнгөрсөн онд болсон Түрэгийн улсуудын байгууллагын 11 дэх дээд хэмжээний уулзалтаар БНТУ-ын Ерөнхийлөгч Р.Эрдоган гишүүн улсуудад латин үсгийн нэгдсэн түрэг цагаан толгойд шилжихийг уриалсан нь Анкарагийн ашиг сонирхлыг дахин нотолсон гэж болно⁶.

Түрэгийн улсуудын байгууллага нь ирээдүйд Төв Азид Оросын нөлөө бүхий ТУХН, ХАБГБ, ЕАЭЗХ болон Хятадын “Бүс ба Зам” санаачилга, ШХАБ-ыг сулруулах гол хэрэгсэл, Туркийн ашиг сонирхлыг хамгаалах гол механизм болон хувирах магадлалтай. Алсдаа энэ бодлого хүчээ авч хэрэгжвэл Төв Ази дахь одоогийн Оросын ертөнц, ирээдүйд Түрэгийн ертөнцөөр солигдоно гэсэн үг. Эерэг тал нь Түрэгийн ертөнцийн нөлөөгөөр Төв Азийн улсуудад Исламын хэт даврагч үзэл, дотоодын тогтворгүй байдал, улс төр, нийгмийн зөрчилдөөн, байгаль орчны асуудал, бэлчээр газар нутаг, хилийн маргаан, үндэстэн хоорондын мөргөлдөөн зэрэг аюул, заналхийлэл аажмаар буурч, хамтын ажиллагаа, интеграц давамгайлж болзошгүй юм. Харин Төв Азийн усны нөөцийн дээд хэсэгт орших Киргиз болон Тажикистаны Засгийн газар усан цахилгаан станцаа өргөжүүлэн эрчим хүч үйлдвэрлэж, экспортлох сонирхол нэмэгдэх нь доод хэсэгт орших Казахстан, Узбекистан, Туркменистаны хүн амын амжиргаанд усны хомсдол үүсгэх эрсдэлтэй.

Киргиз-Тажикистаны хил дээр 2022 оны есдүгээр сард зэвсэгт мөргөлдөөн болж, олон арван энгийн иргэд амь үрэгдсэнтэй холбогдуулан талууд хилийн заагийг тогтоох яриа хэлэлцээг хоёр жил хийсний эцэст, 2024 оны сүүлчээр улсын хилийн маргаантай хэсгүүдээр зарчмын тохиролцоонд хүрсэн нь Төв Азийн аюулгүй байдлын орчныг бэхжүүлэх чухал алхам болсон. Гэвч талууд ус, гол мөрний хил заагийг хараахан бүрэн тогтоогоогүй нь дахин маргаанд хүргэх эрсдэлтэй хэвээр байна.

ОХУ Төв Ази дахь ашиг сонирхлоо хадгалахын тулд Тажикистанд байршуулсан 7000 цэрэг, Киргизийн Кант дахь агаарын бааз, Казахстан дахь Байконурын сансрын буудал, радиолокацын станц болон туршилтын талбайнуудаа хэвээр хадгалах, бүс нутгийн улсуудад харьцангуй хямд үнээр зэвсэг нийлүүлэх, агаарын довтолгооноос хамгаалах, цэргийн алба хаагчдыг сургах, хамтарсан цэргийн сургуулилт хийх замаар цэрэг-стратегийн нөлөөгөө бэхжүүлэх бодлого баримталж байна⁷. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Казахстанд 2024 оны 11 дүгээр сарын 27-нд айлчилж, ХАБГБ-ын дээд хэмжээний уулзалтад оролцсон бол ОХУ, БНУЗБУ 2030 он хүртэл хөгжүүлэх Цэрэг-стратегийн түншлэлийн хөтөлбөрт 2025 оны нэгдүгээр сарын 22-нд гарын үсэг зурсан нь ОХУ-ын Төв Ази дахь цэрэг-стратегийн бодлогын үргэлжлэл гэж харж болно⁸. ХАБГБ-ын “бүтэлгүй” байдлаас улбаалан ОХУ цаашид Төв Азийн холбоотон, түнш улсуудтай хоёр талын аюулгүй байдлын гэрээг илүү чухалчилж болохыг Орос-Узбекистаны Цэрэг-стратегийн түншлэлийн дээрх хөтөлбөр харуулж байна.

⁶ Business-gazeta, <https://www.business-gazeta.ru/article/647922>, (Татсан: 2025.11.01)

⁷ BBC, <https://www.bbc.com/news/world-asia-19849247>, (Татсан: 2025.11.01)

⁸ The Moscow Times, <https://www.themoscowtimes.com/2025/01/22/russia-and-uzbekistan-sign-military-strategic-partnership-plan-a87693>, (Татсан: 2025.11.02)

БНХАУ нь Төв Азийн улсуудтай сайн харилцаа тогтоож, хөрөнгө оруулах, итгэлцлийг бэхжүүлэх, аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах замаар цэргийн оролцоогоо нэмэгдүүлж болзошгүй. Төв Азийн улсуудад Оросын цэрэг-стратегийн нөлөө хэдий чинээ буурна, тэр хэмжээгээр Хятадын нөлөө ихсэж, алсдаа Турктэй сөргөлдөж болзошгүй юм.

Афганистанаас НАТО-гийн цэрэг гарсантай холбогдуулан Ерөнхийлөгч Д.Трампын өмнөх засаглалын үед батлагдсан Төв Азийн талаар АНУ-ын стратегийг тус улсын шинэ засаг захиргаа шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх магадлалтай байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш Төв Азийн таван улсад 2024 оны зун айлчилсан нь тэдгээр улсын дэмжлэгтэйгээр Афганистаныг сэргээн босгох, бүс нутагт салан тусгаарлах, хэт даврах үзэл, терроризмтэй тэмцэх, хүний эрх, хүйсийн тэгш байдлыг дэмжих, энхийг сахиулах, уур амьсгалын бэрхшээлийг даван туулах зэрэг зорилгыг агуулж байна.

БНКазУ-ын Ерөнхийлөгч К.Токаевын санаачилгаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор НҮБ-ын Төв Азийн Тогтвортой хөгжлийн төвийг Алмата хотод 2025 оны гуравдугаар сарын 4-нд нээсэн нь бүс нутгийн улсуудад чухал ач холбогдолтой болов. Энэхүү төвийг томоохон эдийн засагтай Казахстанд байгуулсан нь Афганистанд тогтвортой хөгжлийг дэмжих, шилдэг туршлагыг хуваалцах, техникийн туслалцаа үзүүлэх, хамтарсан төслийг хэрэгжүүлэх замаар Төв Азид аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилготой.

Афганистанд өсөн нэмэгдэж буй эдийн засаг, хүмүүнлэгийн хямралыг даван туулах, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд дэлхийн улс орнууд, олон улсын улс төр, нийгэм хүмүүнлэг, банк санхүүгийн байгууллагууд Талибаны засаглалыг албан ёсоор хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд орох төлөвтэй байна. Тухайлбал: Орос, Хятад, Пакистан болон Төв Азийн улсууд Талибаны томилсон элч, төлөөлөгчдийг албан ёсоор итгэмжилсэн бөгөөд одоогоор дэлхийн 30 гаруй улс Талибаны засаглалтай ямар нэгэн байдлаар харилцаатай байна. Гэхдээ Төв Азид төвлөрч байсан ШХАБ-ыг өргөжүүлж, Евроазийн аюулгүй байдлын гол механизм болгох ОХУ, БНХАУ-ын бодлого нь Төв Азид түрэн орж ирж буй Түрэгийн ертөнц, Талибаны нөлөөг саармагжуулах зорилготой.

Төв Азийн Казахстан, Киргиз, Тажикистан зэрэг гурван улсыг хамруулсан ХАБГБ нь бүс нутгийг НАТО, Бээжингийн цэргийн нөлөөллөөс тусгаарлаж, харин Оросын цөмийн хамгаалалт болон агаарын довтолгооны нэгдсэн тогтолцоо хэвээр хадгалагдах төлөвтэй байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) нь Төв Азид аюулгүй байдлыг эрт сэрэмжлүүлэх, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, зуучлах, зөвлөх зэрэг “зөөлөн хүч”-ний уламжлалт үүргээ хэвээр хадгалах⁹ бол

⁹ Researchgate, https://www.researchgate.net/publication/358310294_The_osce_in_Central_Asia_Engagement_Presence_Problems, (Татсан: 2025.11.02)

Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (АХАИББХ буюу CICA) нь Казахстаны “ивээл”-ээс гарч олон улсын бие даасан байгууллага болон хөгжих хандлагатай байна.

Төв Азийн улсуудад бодитойгоор оршиж байгаа салан тусгаарлах хандлага, хил хязгаар, газар нутаг, усны маргааны асуудлаа зөвхөн яриа хэлэлцээ, энх тайвны замаар шийдвэрлэх, олон улсын тавцанд аюулгүй байдал, дипломат бодлого, эдийн засаг, байгаль орчны асуудлаар нэгдмэл байр суурьтай байх, аюулгүй байдлаа хамтын хүчээр хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Казахстан голлох үүрэг гүйцэтгэхээр байна.

ОХУ 2022 онд Украинд “Цэргийн тусгай ажиллагаа” эхлүүлснээс хойш Төв Азийн улсуудын Төрийн тэргүүн нарын хоорондын хувийн харилцаа сайжирч, хамтдаа Орос, Хятадаас хараат байдлаа бууруулах, гуравдагч улс гүрний дэмжлэг авах, тулгарч буй ус, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, аюулгүй байдлын сорилтууд, түүний дотор Афганистаны асуудлыг шийдэх зэргээр хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чигтэй байна.

Киргизийн Чолпон-Ата хотод 2022 оны долоодугаар сард болсон Төв Азийн улсуудын Төрийн тэргүүн нарын IV дээд хэмжээний зөвлөлдөх уулзалтаар “Төв Азийн улсуудын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан нь бүс нутагт тулгарч буй аюулгүй байдлын сорилт, нийгэм-эдийн засгийн асуудлаа гадны оролцоогүйгээр өөрсдөө бие даан шийдэх алсын харааг илэрхийлж байна. Төв Азийн улсуудыг гэрээ байгуулахад хүргэсэн гол шалтгаан нь Казахстаны 2022 оны үймээн самуун, Узбекистаны Каракалпакстан автономит улсад гарсан бослого, Киргиз-Тажикистаны хилийн маргаан, Украин дахь Оросын цэргийн тусгай ажиллагаа юм.

Зураг 1. Төв Азийн улсуудын Төрийн тэргүүн нарын VI дээд хэмжээний уулзалт, Астана, 2024 он



Эх сурвалж: <https://www.akorda.kz/ru/pod-predsedatelstvom-kasym-zhomarta-tokaeva-sostoyalas-vi-konsultativnaya-vstrecha-glav-gosudarstv-centralnoy-azii-971327>

Душанбе хотноо 2023 оны есдүгээр сард зохион байгуулсан Төв Азийн улсуудын Төрийн тэргүүн нарын V дээд хэмжээний зөвлөлдөх уулзалтаар бүс нутгийн хуурай замын тээврийн холболтыг бэхжүүлэх хэлэлцээр, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих замын зураглалыг баталсан бол Астана хотноо зохион байгуулсан VI уулзалтаар олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын алсын харааг төлөвшүүлэхийг онцолсон. Харин VII дээд хэмжээний уулзалтыг 2025 оны 11 дүгээр сард Ташкент хотод болно хэмээн БНУЗБҮ-ын Ерөнхийлөгч Ш.Мирзиёев мэдэгдэж байна¹⁰.

Төв Азийн улсуудын дээд хэмжээний уулзалт, гэрээ хэлэлцээр нь хамтын аюулгүй байдлын механизмийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үйл ажиллагаа нь бүс нутагт эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, гадаадын хөрөнгө оруулалт татах, байгалийн баялгаа ашиглах, эдийн засгийн интеграцад орох, эрчим хүч, дэд бүтэц, тээвэр логистикийн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд илүү чиглэх төлөвтэй байна.

Тус бүс нутагт өнгөрсөн гучаад жилийн турш өрнөсөн улс төрийн ширүүн уур амьсгал нь цаашид хамтын ажиллагаа, харилцан итгэлцлээр солигдох хандлагатай. Тухайлбал: Узбекистаны өмнөх Ерөнхийлөгч Ислам Каримов улс орноо тусгаарлах бодлого явуулж байсан бол шинэ Ерөнхийлөгч Ш.Мирзиёев дөрвөн хөрштэйгөө харилцаагаа сайжруулж, хил хязгаар, газар нутгийн маргаанаа шийдвэрлэж байгааг дурдаж болох юм.

Ирээдүйд Төв Азийн улсууд Туркийн шууд оролцоо, Түрэгийн улсуудын байгууллагад тулгуурлан Евроазийн өргөн орон зайд эдийн засгийн шинэ холбоог үүсгэх боломжтой ч ОХУ, БНХАУ, АНУ зэрэг их гүрэн саад тотгор болж, түүнийг саармагжуулах бодлого явуулах магадлалтай. Тиймээс Төв Азийн хөгжлийн хамгийн боломжит хувилбар бол одоогийн статус квог үргэлжлүүлэх явдал юм. Бүс нутгийн улс төр, эдийн засгийн тогтвортой хөгжил, Хятадын эдийн засгийн сонирхол, “зөөлөн хүч”-ний бодлого, Оросын цэрэг-улс төрийн нөлөө, Америк, ЕХ, Япон, Өмнөд Солонгос зэрэг гуравдагч этгээдийн хөрөнгө оруулалт, бүсийн тээвэр, логистикийн сүлжээ, эрчим хүчний зангилаа нь Төв Азийн улсуудад сорилт болон нийгэм-эдийн засгийн хөгжлийг зэрэг авч ирэх төлөвтэй байна.

Төв Азийн улсууд дэлхийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой хөгжил, байгаль орчны төлөө НҮБ-тай хамтын ажиллагаагаа чухалчилж, Цөмийн зэвсэггүй бүс, зэвсэг хураахтай холбоотой олон улсын төсөл, санаачилга хэрэгжүүлэх, түүний дотор хими, биологи, цацраг, цөмийн эрсдэлийг бууруулах, Арал тэнгисийг аврах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой байна. Тухайлбал: Афганистаны аюулгүй, тогтвортой байдлыг хангах, нийгэм-хүмүүнлэгийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн дэд бүтцийг сэргээх, тус улсыг бүсийн хамтын ажиллагаанд татан оролцуулснаар Төв Ази нь геополитикийн бие даасан “тоглогч” болох боломжтой.

¹⁰ Gazeta, <https://www.gazeta.ru/politics/news/2025/10/09/26921324.shtml>, (Татсан: 2025.11.01)

Төв Азийн бүсэд дулаарал 1.5 хэмээр нэмэгдэж байгаа нь цэвдэг хайлах, мөс цасны нөөц багасах, хуурайшилт ихсэхэд хүргэж, 2050 он гэхэд Амударья мөрөнд цутгах голуудын хэмжээ 10 хувь, Сырдарья мөрөнд цутгах хэмжээ 6 хувиар тус тус багасах магадлалтай байна¹¹. Нөгөө талаас Төв Азид хүн амын өсөлт, хүнсний үйлдвэрлэл, цагаан будаа, хөвөнгийн тариалалт нэмэгдэж байгаа нь нэмэлт усны хэрэгцээ шаардаж байгаа аж. Узбекистан, Казахстан, Туркменистанд газар тариаланд ус их хэмжээгээр шаардлагатай бол Киргиз, Тажикистан нь эрчим хүчинд ашиглах бодлоготой байгаагаас олон жилийн турш ужгирч ирсэн усны маргаан бүс нутгийн орнуудад томоохон сорилт болох төлөвтэй байна.

Дүгнэлт

Төв Азийн улсуудад ус, хил, газар нутгийн маргаанаас үүдэлтэй үндэстэн хоорондын мөргөлдөөн, ядуурал, ажилгүйдэл, ган, цөлжилт зэрэг уламжлалт болон уламжлалт бус сорилтууд зэрэг тулгарч байна. Хэдийгээр исламын шашин, түрэгийн хэл соёл, зөвлөлтийн дараах тусгаар тогтнолын нийтлэг сорилт зэрэг хүчин зүйл бүс нутгийн орнуудыг нэгтгэдэг боловч газар нутгийн маргаан болон усны хомсдолын асуудал эрсдэл дагуулах өндөр магадлалтай хэвээр байна.

Төв Ази нь цаашид их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөний талбар болох эсвэл аюулгүй байдал, улс төр, эдийн засгийн бие даасан томоохон “тоглогч” болох уу гэдэг нь бүс нутгийн улсуудын нэгдмэл ашиг сонирхол, хамтын ажиллагаанаас шалтгаалах болно.

Монгол Улсын хувьд Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдал нь аюулгүй байдлын талаасаа нэн чухал бөгөөд шууд үзүүлэх сөрөг нөлөө одоогоор байхгүй. Харин эдийн засаг талаасаа Зүүн хойд Азийн хэмжээнд хүрэхгүй ч манай улсын баруун бүсийн хөгжилд ач холбогдол нь өсөн нэмэгдэж байгааг ашиглах нь зүйтэй юм. Үүнээс гадна Төв Азийн бүс нутаг цөмийн зэвсэггүй бүс болсон явдал нь энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад хамтарсан “холбогч гүүр”-ийн үүргийг гүйцэтгэх боломжийг нээнэ.

Эх сурвалжийн жагсаалт

ICC, https://en.icc.org.cn/thinktank_theories/intl_observation/399.html

The Astana Times, <https://astanatimes.com/2025/08/decade-of-c51-experts-observe-advanced-regional-cooperation-in-central-asia/>

Jamestown, <https://jamestown.org/program/china-increasing-its-military-presence-in-tajikistan/>

The Diplomat, <https://thediplomat.com/2025/10/washington-to-host-central-asian-leaders-on-november-6/>

Kazcic, <https://kazcic.kz/en/news/pervyi-biznes-forum-s5-iaponiia-prosel-v-astane>

Business-gazeta, <https://www.business-gazeta.ru/article/647922>

¹¹ VB news, https://www.vb.kg/doc/293683_sredney_azii_predrekli_globalnyu_ekologicheskuyu_katastrofy.html, (Татсан: 2025.11.02)

BBC, <https://www.bbc.com/news/world-asia-19849247>

The Moscow Times, <https://www.themoscowtimes.com/2025/01/22/russia-and-uzbekistan-sign-military-strategic-partnership-plan-a87693>

Researchgate, https://www.researchgate.net/publication/358310294_The_osce_in_Central_Asia_Engagement_Presence_Problems

Gazeta, <https://www.gazeta.ru/politics/news/2025/10/09/26921324.shtml>

VB news, https://www.vb.kg/doc/293683_sredney_azii_predrekli_globalnyu_ekologicheskuyu_katastrofy.html

Акорда,

<https://www.akorda.kz/ru/pod-predsedatelstvom-kasym-zhomarta-tokaeva-sostoyalas-vi-konsultativnaya-vstrecha-glav-gosudarstv-centralnoy-azii-971327>

Security and Geopolitical Issues in Central Asia

Erdenetsogt Dorjpalam

Doctor (Ph.D), Senior Expert, erdenetsogt@iss.gov.mn

The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

The countries of Central Asia are united by history, language, culture, religion, landlockedness, post-Soviet independence, and common security challenges. Central Asia's unique geostrategic location and natural resource reserves attract geopolitical interests of major powers.

The "C5+1" partnership in Central Asia, foreign investment, and common interests of regional countries are the main foundations of regional security and sustainable development.

Whether Central Asia will become an arena for geopolitical competition between major powers or an independent major "player" in security, politics, and economics will depend on the common interests and cooperation of Central Asian countries.

Keywords: Relations, cooperation, partnership, trends.

Received: November 15, 2025 | Accepted: December 26, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.